

## СПОРТ ЗААЛААР ҮЙЛЧЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 03 дугаар сарын 23 ны өдөр

Сайнцагаан сум

**СПОРТ ЗААЛААР ҮЙЛЧЛЭХ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Отгонбаатар (цаашид “Заалаар үйлчлэгч” гэх), нөгөө талаас Дундговь аймгийн 1998 төгсөлт Б.Мягмарсүрэн (цаашид “Заалаар үйлчлүүлэгч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцон гэрээ байгуулав.

### ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

Энэхүү Гэрээ нь 2023 оны 03 дугаар сарын 23-ний өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 30 ний өдрийг дуустал хүчинтэй. Заал ашиглах хугацаа 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 30 ний өдрийг хүртэл 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 21:00 цагаас 23:00 цаг хүртэл т 2 цагийн хугацаатай байна.

### Нэг. ЗААЛААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ТӨЛБӨР

- 1.1 Заалаар үйлчлэх төлбөр нь нэг цагийн 30000 мянган төгрөг байх ба төлбөрийг сар бүрийн эхний 20 ны дотор Биеийн тамир, спортын газрын 100080035401 тоот дансанд шилжүүлнэ.
- 1.2 Үйлчлүүлэгч тал төлбөр төлсөн баримтаа өгч, захиалгаа баталгаажуулснаар дараа 7 хоногийн заал түрээслэх эрх нээгдэнэ.

### Хоёр. Түрээслүүлэгч талын эрх үүрэг

- 2.1 Заал хариуцсан ажилтан нь түрээсийн хугацаанд спорт заалны хэрэгслүүд болон эзэмшлийн тавилга эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал хяналт тавьж, зүй бусаар ашигласан гэмтээсэн тохиолдолд шаардлага тавих, нөхөн төлүүлэх эрхтэй.
- 2.2 Зааланд гэрээгээр үйлчлүүлэгч нар нь биеийн тамир, спортод зориулсан форм тогтмол хэрэглэхийг шаардах эрхтэй
- 2.3 Спортын хэрэглэл материал авч гарах, үрэгдүүлэх, дутаах зэрэг хохирол гаргавал 3 дахин өсгөж төлүүлэх эрхтэй.
- 2.4 Үйлчлэгч тал нь заалны түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шаардах эрхтэй.
- 2.5 Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох бөгөөд хэрэглэсэн, хүнд үйлчлэхгүй байх эрхтэй.
- 2.6 Үйлчлэгч тал гэрээгээр тохиролцсон хугацаанд спорт заалыг чөлөөлж, шаардлагатай хэрэгслээр хангах үүрэгтэй.
- 2.7 Спорт заал хариуцсан ажилтан шаардлагатай хэрэгслээр хангаж, заалыг цэвэрлэж түрээслэгч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 2.8 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг сар бүр төлж барагдуулснаар гэрээг хүчинтэйд тооцно.
- 2.9 Зайлшгүй ажлын шаардлага гарсан тохиолдолд гэрээт байгууллагад цаг ашиглах тухай мэдэгдэх үүрэгтэй

### Гурав. Түрээслэгч талын эрх үүрэг

- 3.1 Үйлчлүүлэгч тал нь спорт заалаар үйлчлүүлэхдээ байгууллага төлөөлж ажиллах албан хаагчийг томилсон байх үүрэгтэй.
- 3.2 Спорт заалыг хүлээн авах үед ариун цэврийн шаардлага хангахгүй бохир гэж үзвэл заал зохион байгуулагчаар дахин цэвэрлүүлэх эрхтэй.
- 3.3 Шаардлагатай тохиолдолд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр тоглолтын хуваарьт цагийг сард 1 удаа хойшлуулах эрхтэй. /88644677 утсаар холбогдож мэдэгдэх/

- 3.4 Хүндэтгэн үзэх шалтгаангүй, урьдчилан мэдэгдэлгүй хуваарьт цаг ашиглаагүй бол төлбөрийг ашигласнаар тооцож төлөх үүрэгтэй.
- 3.5 Үйлчлүүлэгч заал ашиглаж байх хугацаандаа 00-ийн өрөөний тоног төхөөрөмж, хэрэгслийг ариг гамтай ашиглах үүрэгтэй. /эвдэлж гэмтээсэн тохиолдолд хохирлыг төлж байгууллагыг хохиролгүй болгох/
- 3.6 Үйлчлүүлэгч байгууллага нь гэрээнд заасан цагийн хуваарийн дагуу цаг баримтлах үүрэгтэй. /хоцорсон хугацааг нөхөж сунгахгүй/
- 3.7 Заалны тоглолтын талбайд гадуур өмссөн гуталтай явахгүй байх, улавч байнга өмсөх үүрэгтэй.
- 3.8 Бөмбөг болон бусад хэрэглэх материалыг тухайн байгууллага авч ирнэ.

#### **Дөрөв. Хориглох зүйл**

- 4.1 Спортын тоног төхөөрөмж, бөмбөгийг зориулалтаар нь ашиглах бөгөөд ханын самбар, цонх, хаалга, хана руу шидэх, суух, өшиглөхийг хориглоно.
- 4.2 Зөвхөн түрээслэгч байгууллагын ажилтан, албан хаагч орох ба өөр байгууллагатай хамтарч орохийг хориглоно. Хамтарч орсон тохиолдолд хүний тоо 20 оос хэтрэхгүй байна.
- 4.3 Ус ундааны сав, хог цаасыг зориулалтын саванд хийхгүй ил хаяхыг хориглоно.
- 4.4 Тамхи татах цэгээс бусад газарт тамхи татахыг хориглоно.
- 4.5 Хориглосон зүйл зөрчих болон гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

#### **Тав. Бусад зүйл**

- 5.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгална.
- 5.2 Гэрээнд өөрчлөлт орвол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

#### **Зургаа. Талуудын хаяг**

Заалаар үйлчлэгч:

Хаяг: Сайнцагаан сум 7-р баг  
Утас: 70592394, 89694069

БТСГазрыг төлөөлж  
Дарга А.Отгонбаатар

Гарын үсэг: \_\_\_\_\_

/Тамга, тэмдэг/  
310A0035 9033553

Заалаар үйлчлүүлэгч:

Хаяг: : 1998 оны төгсөлтийг төлөөлж  
89997871

Б.Мягмарсүрэн

Гарын үсэг: \_\_\_\_\_

/Тамга, тэмдэг